

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ **/шинэчилсэн найруулга/**

2017 он

Эрүүгийн хууль нь 30 бүлгээс бүрдэх бөгөөд 10-30 дугаар бүлэгт 206 төрлийн гэмт хэргийг хуульчилсан.

2015.12.03-ны өдөр батлагдсан энэхүү хууль нь

- 2016.08.30
- 2017.02.02
- 2017.05.11
- 2017.05.18
- 2017.05.31
- 2017.06.09-ний өдрүүдэд тус тус нэмэлт өөрчлөлтүүд орж, 2017.07.01-ний өдрөөс хэрэгжиж байна.

ОНЦЛОГ 1. 2002 онд батлагдсан өмнөх Эрүүгийн хуультай харьцуулахад ялын төрөл өөрчлөгдсөн.

2002 оны хууль

- Торгох
- Эрх хасах
- Албадан ажил хийлгэх
- Хорих
- Эд хөрөнгө хураах
- Баривчлах
- Цаазаар авах

2017 оны хууль

- Торгох
- Эрх хасах
- Нийтэд тустай ажил хийлгэх
- Хорих
- Зорчих эрхийг хязгаарлах

Цаазаар авах, баривчлах, эд хөрөнгө хураах ялыг халж, зорчих эрхийг хязгаарлах ялыг нэмсэн байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг 1 сараас 5 жил хүртэл хугацаагаар оногдуулах бөгөөд шаардлагатай бол бусад хүнтэй харилцахыг хориглож болно.

ОНЦЛОГ 2. Хуулийн этгээдэд ял оноодог болов.

Гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд дор дурдсан ял оногдуулна.

1. Торгох
2. Эрх хасах
3. Татан буулгах

1. Торгох ял

Хуулийн этгээдийг 10.000-400.000 нэгжтэй тэнцэх /10 сая-400 сая/ төгрөгөөр торгоно.

2. Эрх хасах ял

Хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг 1 жил-8 жил хүртэл хугацаагаар хасна.

3. Татан буулгах ял

Террор үйлдэх, террор үйлдэхэд бэлтгэх гэмт хэргийг хуулийн этгээдийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол татан буулгах ялаар шийтгэнэ.

ОНЦЛОГ 3. Өсвөр насны хүнд оногдуулах ялын төрөлтэй болсон.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд дор дурдсан ял оногдуулна.

1. Нийтэд тустай ажил хийлгэх
2. Зорчих эрхийг хязгаарлах
3. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих

Өсвөр насны хүн гэж гэмт хэрэг үйлдэх үедээ 14 нас хүрсэн ба 18 нас хүрээгүй байсан хүнийг ойлгоно.

1. Нийтэд тустай ажил хийлгэх

Өсвөр насны хүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуунд харшлахгүй ажил хийлгэнэ. 60-240 хүртэл цагаар тогтооно.

2. Зорчих эрхийг хязгаарлах

Өсвөр насны хүнд уг ялыг оногдуулахдаа эдлэх хугацааг 2 дахин бууруулна.

3. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих

Өсвөр насны хүнд уг ялыг оногдуулахдаа эдлэх хугацааг 2 дахин бууруулна. Хоригдож буй үед ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалт зохион байгуулна.

ОНЦЛОГ 4. Гэм буруугаа хүлээн зөвшөөрч учруулсан хохирлоо нөхөн төлвөл ял хөнгөрүүлнэ.

Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлж, хохирогчтой эвлэрсэн бол үйлдсэн гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялыг хөнгөрүүлэхээр заасан.

11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах

1. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан бол 10 сая-40 сая төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн;

2.2. хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн;

2.3. бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж үйлдсэн;

2.4. зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн;

2.5.энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ хуульд заасан “зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулж ойлгоно. Зэвсэг нь галт, хүйтэн, хийн, үйлдвэрийн, гар хийцийн аль нь ч байж болно. “Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан хүйтэн зэвсэг, галт зэвсэг, эд зүйл, хэрэгслийг ойлгоно.

11.3 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах

1. Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл бусад болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол нэг жил хүртэл хугацаагаар эрх хасаж зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол 5.400.000-27.000.000 төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах

1. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулсан бол 450.000-5.400.000 төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар;

2.2. хохирогчийг тохуурхан доромжилж;

2.3. бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж үйлдсэн бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

11.5 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах

1. Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас хүний бие махбодид удаан хугацаагаар эрүүл мэндийг нь сарниулж хөдөлмөрийн чадварын гуравны нэгээс дээшгүйг алдагдуулсан гэмтэл болгоомжгүй учруулсан бол 450.000-2.700.000 төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний эрүүл мэндэд болгоомжгүйгээр хүндэвтэр хохирол учруулсан бол 450.000-5.400.000 төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах

1. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан бол 450.000-1.350.000 төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол 450.000-2.700.000 төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх

1. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга:

1.1. зодсон;

1.2. харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан;

1.3. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн;

2.2. асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн;

2.3. таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

